



ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Хөгжмийн урлаг

Индекс: 021501 бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч:

Дагва овогтой Энхцэцэг

Гишүүд:

Данзан овогтой Энхцэцэг

Халтар овогтой Энхжаргал

Улаанбаатар хот

2023 он

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Оюутнуудын нэрс

II. Багш, ажилчдын нэрс

III. Төгсөгчдийн нэрс

IV. Ажил олгогчдын нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АНУ-Америкийн нэгдсэн улс
БД-Богино дуу
БЗХӨ-Бэлгийн замын халдварт өвчин
БМИҮЗ-Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
БНАСУ-Бүгд найрамдах ардчилсан солонгос улс
БНСУ-Бүгд найрамдах солонгос улс
БНХАУ-Бүгд найрамдах хятад ард улс
БСШУСЯ-Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
БУБ-Багш урлагийн боловсрол
БУБ-Багш урлагийн боловсрол
БУС-Бүжгийн урлагийн сургууль
БХИС-Батлан хамгаалахын их сургууль
ДБМУС-Дээд боловсролын мэдээллийн удирдлагын сургууль
ДБЭТ-Дуурь бүжгийн эрдмийн театр
ДДУС-Дүрслэх дизайн урлагийн сургууль
ДДХСПБ-Дорно дахины хөгжим судлалын профессорын баг
ДУ-Дуулах урлаг
ЕБС-Ерөнхий боловсролын сургууль
ЕБС-Ерөнхий боловсролын сургууль
ЗЗХ-Захиргааны зөвлөлийн хурал
МИ-Магадлан итгэмжлэл
МУАЖ-Монгол улсын ардын жүжигчин
МУГЖ-Монгол улсын гавьяат жүжигчин
МУЗГ-Монгол улсын засгийн газар
МУК-Монгол Улсын Консерватори
МУСГЗ-Могол улсын соёлын гавьяат зүтгэлтэн
МУУГЗ-Монгол улсын урлагийн гавьяат зүтгэлтэн
МҮҮИТ-Монголын үндэсний урлагийн их театр
НДУУ-Найрал дуу удирдах урлаг
ОБЕГ-Онцгой байдлын ерөнхий газар
ОУЭШХ-Олон улсын эрдэм шинжилгээний хурал
ОҮХГ-Оюутны үйлчилгээ хөгжлийн газар
ОХУ-Оросын холбооны улс
ӨМӨЗО-Өвөр монголын өөртөө засах орон
РТМУС-Радио телевиз медиа урлагийн сургууль

СА-Сургалтын алба
СБЗГ-Сургалтын бодлого зохицуулалтын газар
СС-Соёлын сургууль
СУИС-Соёл Урлагийн Их Сургууль
ТББ-Төрийн бус байгуулга
ТВ-Телевиз
ТС-Төрийн соёрхолт
ТШ-Төрийн шагналт
УБХАГ-Уран бүтээл хамтын ажиллагааны газар
УД-Уртын дуу
ҮУТ-Үндэсний урлагийн тэнхим
ХДТ-Хөгжимт драмын театр
ХЗ-Хөгжмийн зохиомж
ХН-Хөгжмийн найруулагч
ХОТ-Хөгжмийн онолын тэнхим
ХСҮТ-Хавдар судлалын үндэсний төв
ХС-Хөгжим судлал
ХУС-Хөгжмийн урлагийн сургууль
ХУТ-Хөгжимдөх урлагийн тэнхим
ХУ-Хөгжимдөх урлаг
ХЦДБЧ-Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга
ЦДБЭЧ-Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга
ЦЕГ-Цагдаагийн ерөнхий газар
ЦХС-Цэргийн хөгжмийн сургууль
ЧДБА-Чанарын баталгаажуулалтын алба
ЧД-Чингэлтэй дүүрэг
ШУС-Шинжлэх ухааны сургууль
ЭМД-Эрүүл мэндийн даатгал
ЭНБД-Эрдэмтэн нарийн бичгийн дарга
ЭШБХ-Эрдэм шинжилгээний бага хурал
ЭШИГ-Эрдэм шинжилгээ инновацийн газар
ЭШ-Эрдэм шинжилгээ
ЮНЕСКО- United Nations Educational, Scientific and Cultural Organization
АТЕС- Asian Theatre Education Communication
CDIO- Conceiving- Designing- Implementing- Operating
ELIA- Европын урлагийн сургуулиудын холбоо
EQ-ARTS-European higher arts education

ISCED- International Standard Classification of Education

ITUA-Introduce, Teach, Use, Assess

KNUA-Korean national university of arts

KPI- Key performance indicator

OGSM- objective, goals, strategies, and measures

PC-Personal Computer

PDCA-Plan, Do, Check, Act

PEO- professional employer organization

PLO-program learning outcomes

SWOT- strengths, weaknesses, opportunities, and threats

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Соёл Урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль MNUAC Mongolian National University of Art and Culture Хөгжмийн онолын тэнхим -Department of Music Theory Хөгжмийн урлагийн сургууль - School of Music arts	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Хөгжмийн урлаг Musical arts program	
Индекс	021501 бакалавр	
Шинжээчид	1. Ахлагч: Д.Энхцэцэг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Багшийн сургуулийн дэд профессор 2. Гишүүн: Д.Энхцэцэг Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн Соёл урлагийн нэвтрүүлгийн редакцийн редактор 3. Гишүүн: Х.Энхжаргал Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэнгийн Урлагийн сургалтын хөтөлбөрийн судалгаа хариуцсан ЭШ-ний ажилтан	
БМИУЗ-ийн зохицуулагч	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч П.Оргилмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2023.03.27	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2023.03.27	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2023.03.31	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.04.03, 05	Шинжээчид сургууль дээр ажиллана.
	2023.04.14	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.04.15	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.04.16	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.

	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

СУИС-ийн Хөгжмийн онолын тэнхимийг 1993 онд байгуулж хөгжим болоод дуулаачийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад хөгжмийн онолын суурь, гүнзгийрүүлсэн сургалтыг явуулж, анхны эрхлэгчээр хөгжим судлаач, урлаг судлалын ухааны доктор (Ph.D) Д.Оюунцэцэг ажиллан, хөгжмийн судалгаа шинжилгээг хөгжүүлэх эхлэлийг тавьсан. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг их дээд сургуулийн жишигт нийцүүлэх боловсруулалт байнга хийгдэж, хөгжим судлал, зохиомжийн чиглэлийн сургалтын баримт бичгийг сайжруулан Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн мэргэжлийн комиссоор батлуулан хэрэгжүүлж байсан. Энэ хугацаанд:

1994 оноос найрал хөгжмийн удирдаач, найрал дууны удирдаач, хөгжим судлаач, хөгжмийн зохиолч мэргэжлээр, 1996 оноос Хөгжмийн онолын тэнхимийн дэргэд эстрад дууны мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн.

2001 оноос хөгжимт жүжгийн найруулагч мэргэжлийн, 2004 оноос хөөмийч мэргэжлийн сургалтыг нэмж явуулах болсон.

2012-2013 оны хичээлийн жилээс Хөгжмийн онолын Тэнхим, Хөгжимдөх урлагийн /үндэсний болон сонгодог/ тэнхимтэй нэгдэн Хөгжмийн Урлагийн тэнхим нэртэйгээр сургалтын үйл ажиллагааг явуулж байсан бол, 2014 оны СУИС-ийн бүтцийн өөрчлөлтөөр, хөгжимдөх урлаг болоод хөөмийн хөтөлбөрийг салган Үндэсний Урлагийн тэнхимийн харьяанд оруулж, Соёлын боловсролын сургуулиас хөгжмийн багшийн ангийг нэгтгэн Хөгжмийн онол, сурганы тэнхим болон өргөжсөн.

Мөн онд "Дээд боловсролын шинэчлэл"-ийн хүрээнд Хөгжим судлал, Хөгжмийн зохиомж, Найрал хөгжмийн удирдаач, Найрал дууны удирдаач, Хөгжмийн найруулга хөтөлбөрүүдийг нэгтгэн “Хөгжмийн урлаг” (021501) нэг багц хөтөлбөр болгон хэрэгжүүлэх болсон.

2017 оноос “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөр бие даан тусдаа гарснаар “Хөгжмийн урлаг” хөтөлбөрөөр дангаараа сургалтаа явуулж эхэлсэн.

Монгол улсын дээд боловсролын тогтолцоонд шинэчлэл хийх бодлогын дагуу 2010 оноос Их сургуулийн түвшинд сургалт явуулж эхэлснээр “Мэргэжлийн хөгжим судлал” профессорын баг байгуулагдан ажиллах болсон нь (Боловсролын хуульд Их сургуулийн үндсэн нэгж нь “профессорын баг” байхаар заасан) ХОТэнхим, “Хөгжмийн урлаг” хөтөлбөрөөр сургалт явуулдаг багш, суралцагсад төдийгүй, СУИС – ийн нийт багш нарын сургалт, эрдэм шинжилгээний хөгжил дэвшилд чухал түлхэц болсон.

Хөтөлбөрийн сайжруулалтын хүрээнд тэнхимийн харьяанд хөгжим сонсголын кабинет, хөгжмийн лаборатори, дуу бичлэгийн студи байгуулан ажиллаж танхимын сургалтыг практиктай хослуулсан нь үр дүнгээ өгсөөр байна.

2020-2021 оны хичээлийн жилээс үр дүнд суурилсан сургалтын боловсролын арга зүй (CDIO)-н зарчмаар хөтөлбөрөө шинэчлэн боловсруулсан.

1993 оноос тэргүүлэх зэргийн мэргэжилтнүүдийг бэлтгэж эхэлсээр өдгөө бараг 30 дахь жилдээ хөгжмийн тэргүүлэх мэргэжлийн уран бүтээлчдийг бэлтгэх сургалтын үйл ажиллагаа амжилттай явагдаж энэ хугацаанд зөвхөн бакалаврын түвшинд 120 орчим боловсон хүчнийг бэлтгэн гаргасан байна. Төгсөгчид нь Монгол орны бүх аймаг, сумын театр, соёлын ордон, хот, дүүргийн мэргэжлийн урлагийн сургууль /МУК, Бадмаараг ахлах сургууль/, ЕБС, ДБЭТ, Монгол улсын филармони, МҮУИТ, ХЦДБЧ, ЦДБЭЧ зэрэг соёл урлагийн байгууллага болон дуу бичлэгийн студийд амжилттай ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар бакалавр, ахисан түвшний өдөр, эчнээ хэлбэрээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, үр дүнг PDCA загвараар шинжилсэн
- СУИС, МУК-ийн сургалтын төлөвлөгөөний харьцуулалт
- СУИС-ийн хөтөлбөрийг АНУ-ын СанФранцеско Урлагийн Их Сургуулийн академи, ОХУ-ын РАМ имени Гнесиний нэрэмжит хөгжмийн академи, Австри улсын Universitet Mozarteum Salzburg сургуулиудын хөтөлбөртэй харьцуулан судалсан
- Хөтөлбөрт хийгдсэн өөрчлөлтүүд-2011, 2014, 2021
- Хөдөө орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагуудад ажиллаж буй хөгжим судлаач, хөгжмийн зохиолч, найруулагч, удирдаачдын судалгаа
- Төгсөгчдийн мэдээлэл сүүлийн 5 жилээр хийгдсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУ-ын МУК төдийгүй өндөр хөгжсөн орны АНУ-ын СанФранцеско Урлагийн Их Сургуулийн академи, ОХУ-ын РАМ имени Гнесиний нэрэмжит хөгжмийн академи, Австри улсын Universitet Mozarteum Salzburg сургуулиудын сургалтын төлөвлөгөөнүүдийг харьцуулан судалж, өөрийн хөтөлбөрөө олон улсын жишигт нийцүүлэн ойртуулахыг зорьж ажиллаж байгаа нь
- Европын боловсролын тогтолцооны TUNING хөтөлбөрийн тодорхой загварыг хөтөлбөртөө тусгасан нь

- Хөдөө орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагуудад ажиллаж буй хөгжим судлаач, хөгжмийн зохиолч, найруулагч, удирдаачдын судалгаанаас эрэлт хэрэгцээгээ олж харж буй нь
- Шаталсан хөтөлбөр хэрэгжүүлж буй нь /Бадмаараг ахлах сургууль-бакалавр-магистр-доктор/

Анхаарах асуудал:

- СУИС-ийн хөтөлбөрийг АНУ-ын СанФранцеско Урлагийн Их Сургуулийн академи, ОХУ-ын РАМ имени Гнесиний нэрэмжит хөгжмийн академи, Австри улсын Universitet Mozarteum Salzburg сургуулиудын хөтөлбөртэй харьцуулан судалсан нь зөвхөн сургалтын төлөвлөгөөний хэмжээн д байна. Цаашид хөтөлбөрийн элемент тус бүрээр харьцуулан судалгаагаа нарийвчлах шаардлагатай.

Зөвлөмж:

- Хөдөө орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагуудад ажиллаж буй хөгжим судлаач, хөгжмийн зохиолч, найруулагч, удирдаачдын эрэлт хэрэгцээнээс гадна УБ хотын мэргэжлийн байгууллагуудын эрэлт хэрэгцээг судлах
- Энэхүү мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, эргэх холбоотой ажиллах бүхий л үйл ажиллагаандаа ажил олгогч болон сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн эрхэм зорилго, Хөгжмийн урлагийн сургуулийн эрхэм зорилго, Хөгжмийн урлаг хөтөлбөрийн зорилгуудын харьцуулалт
- РЕО-PLO-ийн хамаарлын матриц

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн эрхэм зорилго, Хөгжмийн урлагийн сургуулийн эрхэм зорилго, Хөгжмийн урлаг хөтөлбөрийн зорилго ба РЕО-ийн матриц

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх дээр шинжилгээ хийгдээгүй байна.

Зөвлөмж:

- “Хөгжмийн урлаг” Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх дээр шинжилгээ хийх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөөний Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэжлийн кредитийн харьцаа
- Сургалтын төлөвлөгөөний Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэжлийн заавал ба сонгон судлах хичээлийн кредитийн харьцаа
- Сургах арга зүй болон суралцахуйн үр дүнгийн хамаарлын матриц
- PLO-CLO хамаарлын матрицыг зөвхөн “Хөгжмийн зохиомж” хөтөлбөрийг төлөөлүүлэн тайланд оруулсан байна
- заах үйл (ITUA), суралцахуйн үр дүн, сургалтын үйл ажиллагаа, үнэлгээний матриц

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын холбоосыг хичээлийн нэр, код, заагдах улирал, хичээлийн ангилал, уялдсан, багц цагийн мэдээллийг схемээр харуулсан нь
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба PLO хоорондын хамаарлын матрицдаа заах үйл (ITUA)-ийг нь нарийвчлан тодорхойлж өгсөн байна.
- Шалгуур1-ийн TOWS, SWOT шинжилгээ хийсэн.

Анхаарах асуудал:

- PLO-CLO хамаарлын матрицыг зөвхөн “Хөгжмийн зохиомж” хөтөлбөрийг төлөөлүүлэн тайланд оруулсан байна. Гэвч “Хөгжмийн зохиомж” хөтөлбөрөөр суралцагчид 4 жилийн хугацаанд судалдаг бүх хичээлүүдийн CLO-г бүрэн хамруулж чадаагүй байна.
- Тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрүүдийг бүрэн багтаахад анхаарах

Зөвлөмж:

- Тухайн хөтөлбөрийн PLO-үүдийг суралцагчид 4 жилийн хугацаанд судалдаг бүх хичээлүүдийн CLO-уудтай бүрэн матрицлах шаардлагатай.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийн схем
- Сургалтын үйл ажиллагааны сайжруулалтын зураглал
- Сургалтын үйл ажиллагааг шинэчлэн сайжруулсан төлөвлөлт, үр дүнг PDCA загвараар задлан шинжилгээ хийсэн.
- Сургалтын хөтөлбөр, түүний загвар, бүтэц

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2011, 2014, 2021 онуудад Хөтөлбөрт хийгдсэн өөрчлөлтүүд (Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэжлийн кредитийн харьцаа болон заавал ба сонгон судлах хичээлийн кредитийн харьцаа хэрхэн өөрчлөгдсөнийг хүснэгтээр харуулсан)
- Мэргэжлийн хичээлийн уялдаа холбоо, онол практикийн харьцааг тодорхой гаргаж ирсэн байна.
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгын хэрэгжилт /танилцах дадлага, үйлдвэрлэлийн дадлага/
- Суралцагчийн цагийн ачааллын тооцоо

Анхаарах асуудал:

- Тухайн судлагдахууны агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход ямар хувь нэмэр оруулж байгааг тодорхой болгоход анхаарах.
- Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, давхардалгүй, сонгох боломжтой байлгах

Зөвлөмж:

- Дадлагыг чанартай, үр өгөөжтэй хийлгэхэд анхаарч ажиллах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Багшлахуйн үндсэн арга зүйн жагсаалт

- Сургалтын арга зүйг нэгтгэн авч үзсэн түүвэр судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тухайн мэргэжилтэн бэлтгэх онцлогоос шалтгаалан хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй Сургалтын арга зүй хэрэглэгдэж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүй нь мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг эсэх нь өөрийн үнэлгээний тайланд тодорхой харагдсангүй.

Зөвлөмж:

- СУИС-ийн зүгээс хөгжмийн сүүлийн үеийн лицензтэй программ худалдан авах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 5 жилийн байдлаар суралцагчдын голч дүнгийн судалгаа хийгдсэн
- Мэргэшлийн бэлтгэл хангахад уран бүтээлийн тоглолтуудад оролцох, ТВ радиогийн нэвтүүлэгт бэлдэх, хөгжмийн бүтээлийн түүвэрт оролцох, концерт наадам уралдаан тэмцээнд оролцогчдыг бэлтгэх, тодорхой өгсөн чиглэлийн дагуу урлагийн байгууллагуудад урын сангийн судалгаа хийх, уран бүтээлчээр уралдаан тэмцээнд оролцох ажлууд уламжлал болон хийгддэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Онцлог, бусдад туршлага болохуйц зүйл ажиглагдсангүй

Анхаарах асуудал:

- Шинэ уран бүтээлийн тоглолтуудыг үзэх эрхийг оюутнуудад өгч ажиллах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн I байр 1,3-р давхар

- СУИС-ийн II байрны нэгдсэн номын сан
- СУИС-ийн I байрны 1-р давхарт 00 өрөө
- Анги 118. Сургалтын студи, Улсын хэмжээнд анх удаа хөгжмийн зохиомжийн MIDI лаборатори танхим
- Анги 121. Компьютер хэрэглээний хичээл /багш Болормаа/, соноршуулгын хичээл /багш Д.Цэцэрлэг/
- Төрийн шагналт Ц.Нацагдоржийн нэрэмжит Урлагийн номын танхим
- СУИС-ийн II байранд Урлагийн ном хэсэг, CD сонсох өрөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжмийн урлаг хөтөлбөрт оюутнууд ганцаарчилсан хичээлд хамрагддаг нь хөгжмийн мэргэжлийн сургуулийн онцлог юм. Тиймээс анги танхим ихээхэн шаардлагатай байдаг. Мөн ганцаарчилж давтах зайлшгүй шаардлагатай учраас мөн л давтлагын анги хэрэг болдог. Хөгжмийн урлагийн сургуулийн захиргаанаас багш оюутны хичээллэх орчинг сайжруулах, таатай нөхцөл бүрдүүлэхэд байнга анхааран ажилладаг. ХУС-ийн 3-р давхар нь СУИС-ийн хамгийн тохилог таатай цэвэр орчин байгаа нь ажиглагдсан. Энд ХУС-ийн эрхэм зорилго, монголчуудын үнэт зүйлийн жагсаалтыг хадаж, ажил үйлсээ сурталчилсан фото зургийн үзэсгэлэн гаргасан зэрэг нь орчныг тухтай болгож үзэх харах юмтай мэдээлэл сайтайг харуулж байна.

Анхаарах асуудал:

- СУИС-ийн I байрны 1-р давхрын 00 өрөө чийг ихтэй учраас тэнд хичээллэдэг багш оюутны эрүүл мэнд, эко орчинд онцгой анхаарал тавьж хэдийгээр байрны суурь анхнаасаа /1956/ засвар хийх боломжгүй 1-р давхрын суурьтай зайгүй баригдсан ч аль болох засварлаж үнэрийг дарж байх
- Хөгжмийн урлаг хөтөлбөрийн оюутнуудын сурах давтах зохистой нөхцлийг хангахын тулд анги танхимийн хүрэлцээг нэмэгдүүлэх, ялангуяа давтлагын өрөөнүүдийг энд тэндгүй зэрэгцэн хөгжимдөж бусдад саад болохгүйгээр аль болох зохицуулж нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Компьютер хэрэглээний хичээлийн агуулгыг эрс сайжруулах, оюутнуудын сонирхлыг татах, хамгийн орчин үеийн технологийн ололтыг аль болох ойлгож эзэмшсэн багшаар хичээл заалгах, хичээлийг орчин үеийн техник технологийн тусламжтай явуулах, оюутны хөгжил төвийг дэлхийн их сургуулийн оюутны хөгжлийн туршлага судлан идэвхтэй ажиллуулах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлд хэрэглэгддэг ном гарын авлага, ноотнууд
- Лаборатори студи, дуу бичлэгийн студи
- Номын санд байгаа сурах бичиг гарын авлага, орчуулгын номууд
- Багш, оюутнуудтай хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжмийн урлаг хөтөлбөр нь ганцаарчилсан хичээл ихтэй учир багшийн мэдлэг туршлага, ур чадвараас сургалтын үр дүн ихээхэн хамаардаг.
- Ноотон дээр тулгуурлан ажилладагаас хөгжмийн талаарх нарийвчилсан сурах бичиг бага учраас гадаад хэлээр ашиглах нь элбэг байдаг.

Анхаарах асуудал:

- Компьютер тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулахад анхаарах
- Орчин үеийн дэлхийн түвшний программ хангамжийн шинэчлэл хийх, программын зөвшөөрлийг худалдан авахад анхаарах асуудлыг багш нар хөндөж байв

Зөвлөмж:

- Монгол хэл дээр ном сурах бичгийг нэмэгдүүлэхэд анхаарах
- Сургалтын аудио, видео хэрэглэгдхүүн буюу баримтат өв, үзэх харах сонсох эх хэрэглэгдхүүний тоог нэмэх хэрэгтэй
- Багш оюутны цахим мэдлэгийг сайжруулахад түлхэц өгөх янз бүрийн арга хэмжээг зохион байгуулж энэ талаар ур чадвартай багш нарыг урамшуулж дэмжих нь зүйтэй.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Гэрэл зургийн номын сан, Уран зураг, дуулалт хөгжим, кино, театрын урлаг, урлаг судлал, гүн ухаан, соёл урлаг эдийн засаг, менежмент маркетинг, намтар судлал, газар зүй, аялал жуучлал түүх, ардын аман зохиол, сэтгэл судлал, гоо зүй, дүрслэх урлаг, ноот клавира /гадаад, монгол/ сэдэвт ном товхимол
- Номын сангийн эрхлэгч Тунгалагын тайлбар танилцуулга
- Багш оюутнуудтай ярилцсан ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжмийн урлагийн хөтөлбөрт хэрэглэгдэх ном сурах бичиг, гарын авлагыг ихэвчлэн орос хэлээр ашигладаг

Анхаарах асуудал:

- Монгол хэл дээрх ном сурах бичгийг нэмэгдүүлэх
- Хөгжмийн урлагийн хөтөлбөрийн хувьд хамгийн чухал сэдвээр хэрэгцээтэй сурах бичиг, ном ноотны судалгааг гаргах

Зөвлөмж:

- Хөгжим судлаач багш нарт нарийн мэргэжлийн ном товхимол бичих, орчуулга хийхэд цагийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн үнэлгээний тайлан
- Багш нартай хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжмийн урлаг хөтөлбөрийн багш оюутны тэн хагас нь хөгжмийн зохиолч, уран бүтээлчид учраас уралдаанд оролцох, хөгжмийн бүтээл хийхэд ихэнх цаг, авьяас билгээ зориулдаг онцлогтой.

Анхаарах асуудал:

- Багш нарыг хөтөлбөрийн үйл ажиллагааг сайжруулахад дайчлан ажиллах, шууд оролцоог дээшлүүлэхэд тэнхим анхаарч ажиллах
- Уран бүтээлч багш нарын хөтөлбөрт хандах хандлагыг өөрчлөх, оролцоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Хөгжмийн урлагийн хөтөлбөрийг тодорхой хугацаанд шинэчлэн боловсруулж байх нь сургалтыг сайжруулах орчин үеийн технологийн хурд, ур чадвар сэтгэлгээний түвшинд хүргэх ач холбогдолтой
- Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын журмыг шинэчлэн батлах, багш нарын оролцоог дүгнэн “Б” цагт оруулан тооцох боломжтой

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Дотоод гадаадын их дээд сургуулийн хамтын ажиллагааны гэрээ
- АНУ, БНСУ, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-тай багш оюутан солилцоо хийсэн зэрэг туршлага
- Хавдар судлалын үндэсний төв болон бусад ТББ-тай хамтын ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Үгээр хэлэх боломжгүй зүйлийг хөгжмөөр илэрхийлдэг” гэсэнчлэн хөгжмийн нөлөөлөх чадварыг олон түмэнд хүргэх, хөгжмөөр эмчлэх, бясалгах зэрэг олон талын үйл ажиллагааг зохион байгуулж амжилтад хүрч байгаагаараа онцлог. Хөгжмийг сурталчлах, соён гэгээрүүлэх ажилд туршлагажсан сургууль хамт олон юм байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн сургалтын ижил төстэй дотоод /Монгол улсын консерватори/ гадаадын их дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх, багш оюутны солилцоо хийх, мастер класс сургалт семинар зохион байгуулах нь сургалтыг чанартай болгоход нөлөөлнө

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөгжмийн урлагийн сургуулийн төсвийн гүйцэтгэлийн задаргаа /2016-2021 оны байдлаар/
- Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр
- Нийт зардлын дүн: Ажиллагсадтай холбоотой зардал
- Хувьсах зардал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ганцаарчилсан хичээл ихтэй учраас цалингийн зардалд ихэнх санхүүжилт хийгддэг нь хөгжмийн сургуулийн бас нэг онцлог.

Анхаарах асуудал:

- Амралтын мөнгөний олгох хугацааны асуудлаар багш нарын тавьсан саналыг анхаарч судлах

Зөвлөмж:

- Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн хэрээр хөтөлбөрийн төлөвлөлт биелэлтийн үйл ажиллагаанд зарцуулж сургалтын чанарт нөлөөлөх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн холбоо, төгсөгчдийн судалгаа
- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Төгсөгчид, ажил олгогчилтой хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжмийн мэргэжлийн сургуулийн хувьд хөтөлбөрийг тодорхой хугацааны турш шинэчлэн боловсруулж хөтөлбөрийн дэд хороо, ерөнхий хороогоор хэлэлцүүлж баталгаажуулдаг.
- Хөгжмийн урлаг хөтөлбөр нь хөгжмийн суурь боловсролтой авьяаслаг хүмүүс суралцдаг нарийн мэргэжил учраас сонголт хийж авдаг.
- Мэргэжлийн урлагийн байгууллагуудтай хамтран ажиллаж, эрэлт их аймгуудад багш томилон элсэлт авч, сургалт семинар явуулдаг

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах, оюутнуудад эерэг мөрөөдөл, бодит бахархалыг бий болгох, сурах хүсэл эрмэлзэл идэвхийг дээшлүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Хөгжмийн урлаг хөтөлбөрт хамрагдсан үе үеийн бахархалт төгсөгчидтэй уулзалт хийх, нээлттэй ярилцлага өрнүүлэх, подкаст хийх г.м. олон чиглэлээр үр дүнтэй ажиллаж оюутнуудын одоогийн суралцах арга барилд өөрчлөлт хийх хэрэгтэй

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөгжмийн урлаг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч субъектүүд
- СУИС-ийн веб сайтууд цахим хаягууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжмийн урлаг хөтөлбөр нь тэргүүлэх уран бүтээлч бэлтгэдэг үнэ цэнтэй хөтөлбөр юм.

Анхаарах асуудал:

- Мэдээлэл сурталчилгааг улам бүр боловсронгуй хүртээмжтэй болгоход анхаарах

Зөвлөмж:

- Хөгжмийн ухааны тэнхимийн багш нарын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг сурталчлах, түгээх PR хийх хэлбэрийг сайжруулах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Бакалаврын сургалтад элсэхийг хүсэгч нь бүрэн дунд, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх ба Элсэлтийн Ерөнхий Шалгалт (ЭЕШ) өгөн тухайн жилийн Боловсролын яамнаас гаргасан босго оноог давсан байх шаардлагатай бөгөөд элсэхийг хүссэн мэргэжлийн чиглэлийн дагуу ур чадварын шалгалтыг өгнө. Ур чадварын шалгалтыг ерөнхий буюу бүтээлч сэтгэлгээтэй, авьяаслаг ба онцлог буюу хөгжмийн онол, зохиол, олон хоолойн урлаг /полифони/, хөгжмийн хэлбэр, хэв маяг, чиглэлийн үндсэн мэдлэгтэй байх шалгуураар авдаг байна.
- Соёл урлагийн их сургуульд элсэгчдийг Улаанбаатар хотод болон хөдөө орон нутагт мэргэжлийн багш нарын баг томилж, элсэлтийн ажлыг зохион байгуулдаг боловч Их дээд сургуулиудын консорциумын элсэлтийн шалгалтын комиссын бүрэлдэхүүнд хөгжмийн мэргэжлийн хүн ажилладаггүйгээс тус мэргэжлийн хуваарь хоосон буцах, эсвэл мэргэжлийн шаардлага хангахгүй элсэгчид ирдэг.
- 2022.11.18-нд БШУЯ-ны дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газарт МУЗГ-аас баталдаг “Хөгжлийн тэргүүлэх мэргэжлийн чиглэл болон эрэлттэй мэргэжлийн жагсаалт”-тад оруулах соёл, урлагийн чиглэлийн эрэлттэй болон тэргүүлэх мэргэжил, хөтөлбөрийн саналыг хүргүүлсэн. Энэ албан бичгийн хавсралтад дурдсан хөтөлбөрүүд дунд Хөгжмийн урлаг хөтөлбөр багтаж байгаа. Энэхүү саналын хариу одоогоор батлагдаж ирээгүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Соёл урлагийн их сургуулийн бакалаврын болон ахисан түвшний хөтөлбөрт гадаадаас оюутан элсүүлэхийн тулд сургууль тус бүрээс 2-3 багш, ажилтан Хөх хотод элсэлтийг явуулдаг. Хөх хотын элсэлт нь жил бүрийн I, VI саруудад тус тус болдог. Хөтөлбөрт тэнцэх шаардлага хангасан элсэгч нь 8-р сарын сүүлээр Монгол улсад ирж бүртгэл хийлгэн Монгол хэлний түвшин тогтоох шалгалтыг өгдөг. Элсэгч хэлний шалгалтад тэнцээгүй тохиолдолд 6-12 сарын хэлний бэлтгэлд суудаг ба энэ хугацаанд мэргэшүүлэх хичээлээс 8-хүртэл багц цагийг судлуулдаг. Хэрэв элсэгч мэргэжлийн хувьд I курст элсэх шаардлага хангаагүй тохиолдолд Мэргэжлийн бэлтгэл ангид 1 жил суралцах боломжтой.
- Соёл урлагийн их сургуулийн “Дүрэм журмын эмхэтгэл” (2015), ХУС-ийн “Оюутны дэвтэр”, “Оюутны гарын авлага”-ыг шинээр элссэн оюутан бүрд үнэ төлбөргүй тарааж өгдөг.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ЕБС-тай хамтран ажиллах шаардлагатай харагдаж байна.
- Элсэгчдэд UNICULTURE системийн талаарх ойлголтыг тодорхой өгдөг хэдий ч системийн хөгжүүлэлт төдийлөн шаардлага хангаж чадахгүй байгааг анхаарах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан

- Оюутны үйлчилгээ, хөгжлийн газрын дэргэдэх “Оюутны хөгжил төв”-өөс жил бүр хичээлээс гадуур зохион байгуулах үйл ажиллагааны график гарган батлуулж, оюутны хөгжил төлөвшлийн асуудлыг хариуцан урлаг уран сайхан, сургалт семинар, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг.
- Төлөвлөгөөний дагуу ажил хэрэгжиж байгаа эсэхэд Оюутны үйлчилгээ, хөгжлийн газар шууд хяналт тавьдаг бөгөөд хичээлийн жилийн төгсгөлд СУИС-ийн захиргааны зөвлөлийн хуралд тайлан тавьж ажлаа дүгнүүлдэг. Жил бүрийн хавар Оюутны үйлчилгээ, хөгжлийн газарт бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба төлөвлөгөөнд тусгах ажлын саналаа өгч, дараагийн хичээлийн жилийн “Оюутны ажлын график”-ийг ОУХГ-аас нэгтгэн гаргадаг.

-Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал

- Хөгжмийн урлаг хөтөлбөрөөр суралцаж буй I-IV ангийн нийт 17 оюутнаас 5 асуулт бүхий судалгааг авсан байна. Судалгааны үр дүнгээс дурьдахад: Оюутны зөвлөх багш, сургалтын мэргэжилтэн нар оюутанд шаардлагатай үед зөвлөн туслах үйлчилгээг хангалттай үзүүлж чаддаг боловч зарим тохиолдолд хүрч ажиллаж чадахгүй байгаа нь харагдаж байна. Оюутны дотуур байранд амьдарч байгаа оюутнуудын ихэнх хувь өмнө нь ахлах сургуульд суралцаж байх үедээ амьдарч байсан оюутнууд байдаг. Иймд оюутны дотуур байрын багш оюутнууд бие биетэйгээ танил тул ойлголцох нь хялбар болсон байдаг. Сэтгэл зүйчтэй уулзаж зөвлөгөө авч байсан оюутнууд тус хөтөлбөрөөр нийт суралцаж буй оюутнуудын 29,4%-ийг эзэлж байна. Энэ нь оюутнуудын ихэнх хувь сэтгэл зүйчтэй уулзаж зөвлөгөө авч байгаагүй бөгөөд үүнийг нэг талаас оюутнуудын сэтгэл зүйн байдал тогтвортой байгаагаас нөгөө талаас сэтгэл зүйчийн талаар мэдээлэл дутуугаас байж болох учир оюутнуудад сэтгэл зүйчийн талаар мэдээллийг хүргэх хэрэгтэй харагдаж байна.
- Судалгааны үр дүнд үндэслэн дараах сайжруулалтыг хийж байна: Асуулт 5-тай холбоотойгоор сургуулийн “Оюутны хөгжилд зөвлөх багшийн оролцоо” уулзалт сургалтад СУИС-ийн Сэтгэл зүйч Э.Энхсаран Их сургууль дахь сэтгэл зүйн үйлчилгээ, Шинэ үеийн залуусын сэтгэл зүйн онцлог сэдвийн хүрээнд цахим сургалт зохион байгуулсан. Мөн оюутнуудад зориулан 2022.03.16-нд Их сургууль дахь сэтгэл зүйн үйлчилгээ, Зөвлөн ур чадвар (Soft skill) сэдвийн дор цахим сургалт явуулсан.

-Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ

- “Хөсөгтөн” хамтлаг, ХУС-ийн уран сайхны удирдагч Д.Ариунболд, эрдэмтэн Д.Өлзийбаатарын лекцэд багш оюутнууд хамрагдсан. 2018-2019 онд “Сонсох үнэ цэнэ” оюутны ёс зүйг дээшлүүлэх төсөл хэрэгжүүлж 13 эрдэмтэн, багш, төгсөгч ирж 13 удаагийн лекц уншсан.
- Зүйр цэцэн үгс, хэлц үгийн утга тайлал сургалт /Ж.Баянсан багш/ /2018-2019/ “21-р зууны боловсролын чиг хандлага, хөгжмийн нөлөө” сургалт
- Мэргэжлийн ёс зүйн сургалт
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт
- Дээлтэй монгол өдөрлөг
- ЦЕГ-аас хар тамхи мансууруулах бодистой тэмцэх сургалт, лекц
- ОБЕГ-аас гамшгийн зарлан мэдээллийн дуут дохионы дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургуулилт 2016 он ОБЕГ-аас гамшгийн мэдээллийн дуут дохионы дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургуулилт
- “Өгөх өдөр” хүмүүнлэгийн сайн үйлсийн аяны хүрээнд багш, албан хаагч, оюутан 97 хүн хамрагдан 35л цус хандивлан 105 хүний амийг аварсан.
- Бүрэлдэхүүн сургууль дунд зохиогддог спорт наадам /жил бүр/
- Жил бүр хөөсний баяр хийж тогтмолжсон нь эрүүл аж төрөх, бусдыг хүндлэхэд чухал үүрэгтэй.
- Мэргэшүүлэх хичээлийн багш нар оюутнуудын гэр бүлийн хүмүүжил, өмнөх боловсролын байдал, найз нөхдийг нь судлан холбоотой байх, сэтгэл зүйд нь

эергээр нөлөөлөх, зөв төлөвшин хөгжих нөхцөл бүрдүүлэх, хувь хүний болон нийгмийн ёс зүйн хэм хэмжээ, ёс суртахууны эерэг ойлголт, ухагдахууныг ганцаарчилсан сургалтын системээр дамжуулан төлөвшүүлэхэд анхаардаг.

-Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ

- Оюутнууд 3-р ангиасаа курсийн ажлын түвшинд судалгаа хийхээс эхлээд хөгжим судлаач, найрал дуу удирдах, найрал хөгжим удирдах ангийн оюутнууд өөрсдийн сонирхлын дагуу сэдэв сонгон авч дипломын бичвэрийн ажлыг хамгаалах ба оюутны эрдэм шинжилгээний хуралд тухайн судалсан сэдвээр оролцдог байна.
- Тэнхим жил бүр Оюутны эрдэм шинжилгээний хурлыг магистр, бакалаврын оюутнуудын дунд зохион байгуулдаг. Багш нар оюутны төгсөлтийн бичвэрийн ажлыг удирдах явцдаа тэдний судалгааны ажилд шаардагдах судалгааны ажлын онол, арга зүйгээр хангаж ажилладаг. Удирдаж буй оюутнуудаараа судалгааны ажилд хэрэг болох материалуудыг бэлтгэх зорилгоор монголын радио, телевизийн фондтой харьцах, каталог шүүх, эрэн сурвалжилж яриа бичлэг хийх ажлуудыг хийлгэдэг.
- Оюутны судалгаа, шинжилгээ хийх үйл ажиллагааг дэмжих зорилгоор цахим номын баяжилтыг хийх, номын сангийн орчныг тухтай болгох, ном, бичлэгийн фондыг жил бүр баяжуулах ажлыг зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжмийн урлаг хөтөлбөрөөр төгсөж буй оюутан нарийн мэргэжлийн дагуу бичвэрийн ажил, улсын шалгалт, нөгөө хэсэг нь бүтээлийн анотаци бичдэг.
- Оюутны санаачилгын төслөөр “Сонсох үнэ цэнэ” сургалт явагдсан. Үүнд: профессор багш нар, урлаг соёлын нэрт зүтгэлтнүүд, алдар цуутай төгсөгчид урилгаар ирж, оюутнуудад лекц, сургалт, нээлттэй ярилцлага, онол, практикийн хурал, хүмүүнлэгийн сайн үйлсийн аян зэргийг зохион байгуулсан.
- Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын талаар санал гомдол гарсан тохиолдолд хариуцах нэгжээр шийдүүлдэг бөгөөд шийдвэрт хүрээгүй тохиолдолд Соёл урлагийн их сургуулийн ёс зүйн хороогоор хэлэлцэн шийдвэрлэдэг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын ихэнх хувь нь сэтгэл зүйчтэй уулзаж зөвлөгөө авч байгаагүйд анхаарал хандуулах, мөн сэтгэл зүйч ажиллуулах хүсэлтийг оюутнууд гаргаж байсан.
- Түүнчлэн оюутнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, уулзалтыг зохион байгуулах хэрэгтэй байгаа бөгөөд энэ талын мэдлэггүйгээс оюуны өмчийн талаар төдийлөн мэдэхгүй төгсдөг байна.
- Эрдэм шинжилгээний хуралд оюутнуудын оролцоог нэмэгдүүлж, илтгэл хэлэлцүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулах хэрэгтэй байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутан, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор бүрэлдэхүүн сургуулийн оюутнуудын дунд биеийн тамирын тэмцээн уралдаан зохион байгуулдаг.
- Хөгжмийн урлагийн сургууль нь нийт 4 клубтэй бөгөөд мэргэжлийн англи хэлний клубт хөгжмийн урлаг хөтөлбөрийн 4 оюутан, оюутны дотуур байрны “Холбон хэлхье” номын клубт хөтөлбөрийн 3 оюутан явдаг.
- Хөгжмийн зохиомж найруулгын чиглэлээр “MUSIC” уралдаан, хөгжмийн онолын чиглэлээр “OPUS” уралдааныг 2 жилд нэг удаа ээлжлэн зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан суралцах хугацаандаа сайн дурын үйл ажиллагаанд оролцсон байдлыг дүгнэн оюутныг төгсөхөд “Нийгэмд чиглэсэн олон нийтийн ажилд оролцсон батламж”-ийг дипломын хамт олгодог.
- Соёл урлагийн их сургуулиас нийгэмд хандсан, сайн дурын үйл ажиллагаанд багш, ажилтан, оюутнуудтайгаа идэвхтэй оролцож, олон нийтэд соёл урлагийг сурталчлах, ардын уламжлалт соёлыг залуу үеийнхэнд өвлүүлэн үлдээх, гоо зүйн харилцаанд сургах зорилгоор жил бүр “Соёлын наадам”, “Гудамжны баяр” зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг.
- Оюутнуудын дунд “Орлоготой оюутан” хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлдэг бөгөөд сайн дураараа заагдсан ажлын байруудад өөрийн чөлөөт цагаар ажилласнаар оюутанд тодорхой хэмжээний цалин олгодог.

Анхаарах асуудал:

- Тэнхимийн багш нар оюутны нийгэм дэх оролцоог сайжруулах үүднээс сайн дурын үйл ажиллагааг дэмжин удирдаж, зохион байгуулах, оюутны оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх зэрэг асуудал дээр анхаарч ажиллах
- Тэтгэлэг болон оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах асуудлыг анхаарч хамрагдалтыг нэмэгдүүлэх
- Захирлын нэрэмжит тэтгэлэгийн хэмжээг эргэж харах. Зах зээл болон үнийн өсөлтийг дагаад нэмэх хэрэгтэй байгаа талаар оюутнууд ярьж байсан.
- Оюутнуудын сайн дурын клуб ажилладаг боловч үйл ажиллагаа жигд, тогтмол биш байгааг анхаарч эрчимжүүлэх, цаашлаад оюутнуудын өөрсдийн сонирхолд тулгуурласан клубыг үүсгэж ажиллуулах
- Шинээр элссэн оюутнуудыг чиглүүлэх, зөвлөх, шаардлагатай нийгмийн үйлчилгээнд хамруулах, хэрэгцээтэй мэдээ, мэдээллийг түргэн шуурхай түгээх, оюутнууд тухай бүрд нь мэдээллийг авч чадахгүй байгааг анхаарч цаг хугацаанд нь нэг цэгээс бодитой, тодорхой дамжуулж хэвших хэрэгтэй байна. Учир нь хэд хэдэн face групп байдаг. Үүнийг цэгцлэх хэрэгтэй байдаг талаар мөн оюутнууд ярилцлагын үед дурьдаж байлаа.

Зөвлөмж:

- Олон улсын болон дотоодын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөтгөж, багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөрт хамрагдах оюутны тоог нэмэгдүүлэх
- Оюутны хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрүүдийн талаар цаг тухай бүрд нь мэдээллийг хүргэж, зөвлөн туслах
- Өөрийн үнэлгээний тайланд оюутны урамшууллын тогтолцооны талаар харьцангуй бага тусгагдсан байгааг анхаарч нэмж оруулах

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчдын шилжилт хөдөлгөөн СУИС-ийн бакалаврын журмын шилжилт хөдөлгөөний журмаар зохицуулагдана. (Энэхүү журам нь 2012, 2015, 2020 онуудад тус тус шинэчлэн батлагдсан)
- Бусад сургуулиас шилжин ирж буй оюутны гаргасан хүсэлтэд тулгуурлан сургалтын холбогдолтой баримт бичгийн бодит байдал, мэргэжлийн тэнхимийн ур чадварын шалгалтын үнэлгээ зэрэгт үндэслэн шилжүүлэн авах эсэхийг шийдвэрлэнэ.

- Суралцагчдын өөрийн хүсэлтийг харгалзан үзсэний дагуу “Оюутны шилжилт хөдөлгөөн”-ий журмыг үндэслэн жилийн чөлөө олгох, сунгах, үргэлжлүүлэн суралцах, мэргэжил шилжүүлэн суралцах, сургуулиас чөлөөлөгдөх зэрэг үйл ажиллагаануудыг зохицуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Завхан аймаг дахь ХБК, Бадмаараг ахлах сургуулийн төгсөгчдийн хичээл дүйцүүлэлтийг кредит цагийн төлбөрөөс чөлөөлсөн байна.

Анхаарах асуудал:

- Ихэвчлэн өөрсдийн сонирхол хүсэл, авьяас дээр тулгуурлан элсэн суралцаж байгаа болохоор сургуулиас чөлөөлөгдөх, шилжих асуудал харьцангуй бага байдаг байна.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн шалгалтын томилогдсон комисс оюутан бүрээр төгсөлтийн шалгалтын эцсийн дүнг гаргаж, протокол хөтөлнө. Ийнхүү тухайн улиралд төгсөлтийн шалгалт өгсөн, төгсөлтийн ажил хамгаалсан оюутнуудад бакалаврын зэрэг олгох эсэх саналыг төгсөлтийн салбар комиссын хурлаар шийдвэрлэж, гишүүдийн гарын үсгээр баталгаажсан шийдвэрийг бичгээр үйлдэн бакалаврын сургалт хариуцсан захиргааны нэгжид ирүүлнэ. Төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн сургуулиа амжилттай төгссөн төгсөгчдөд бакалаврын зэрэг олгох тухай СУИС-ийн захирлын тушаал гарна.
- Оюутны дипломыг Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай БСШУ-ны Сайдын 2012.01.02-ны 01 дугаартай тушаал, СУИС-ийн Дүрэм, журмын эмхэтгэлийн 10.11-д заасны дагуу кирилл, монгол бичгээр хэвлэдэг бөгөөд 2021 оны хаврын улирлаас эхлэн оюутан хүсвэл дипломыг англи хэл дээр нэмэлтээр авч болох боломжтой болсон.
- Баримт бичгийг хэвлэхээс өмнө сургалтын алба оюутнуудтай дүн тулгалт хийнэ. Дараа нь төгсөлтийн нарийн бичиг дүнд хяналт тавьж мониторинг хийнэ. Үүний дараа Сургалтын бодлого зохицуулалтын мэргэжилтнүүд дипломын дүнд тулгалт хийнэ. Диплом хэвлэсний дараах эрсдэлээс сэргийлж дипломыг канондож дахин мониторинг оруулна.
- Диплом ба дипломын хавсралтыг шинэчлэн солиулах, нөхөн авахыг хүсэгчийн хувийн өргөдлийг үндэслэж нотлох бичиг баримтыг бүрдүүлсний дагуу төгсөлтийн бичиг баримтын баяжилтыг хийнэ. Хэрэв төгсөгч төгсөлтийн дипломыг гээж, үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох материалыг бүрдүүлж хариуцах нэгжид хүсэлт гаргана. Эцэст нь дипломыг шинэчлэн солих, нөхөн олгох тухай асуудлыг бакалаврын сургалт хариуцсан захиргааны нэгж батлагдсан загварын дагуу бичнэ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн шалгалтыг тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийн агуулгын хүрээнд оюутнууд бичвэрийн ажил болон өөрийн зохиосон бүтээл гэсэн 2 төрлөөр (Уран бүтээл, Судалгааны ажил) явагддаг.

Хөгжмийн зохиомж, MIDI зохиомж ангийн оюутнууд бичвэрийн ажлын оронд өөрийн зохиосон бүтээлд анотаци бичдэгээрээ бусад хөтөлбөрөөс ялгаатай юм.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн уулзалтын үеэр хэд хэдэн асуудлыг анхаарах шаардлагатайг хэлж байсан. Тухайлбал,
 - ажлын байрны шаардлагад нийцсэн дадлагыг хийх
 - элсэгч, төгсөгчдийн ноот унших чадварыг дээшлүүлэх
 - дадлага хийх байгууллагатай хамтрах ажлыг чанаржуулах
 - найрал дууны дадлагыг 2-р курсээс эхлүүлэх
- Ажил олгогчдын уулзалтаас дараах саналуудыг төгсөгчидтэй холбон хэлж байсан. Тухайлбал,
 - Төгөлдөр хуурын хичээлд орж байгаагүй, учир нь сонгон судлах хичээл болохоор сонгоогүй гэж хариулсан байна.
 - Элсэлтийн бодлого байхгүй байна. Ажлын байрны судалгаа авч дутагдалтай мэргэжилтэнг бэлтгэх зэргээр бодлогоор сургалтыг явуулах бэлтгэх, МУК- ямар түвшинд мэргэжилтэн бэлтгэх вэ гэдгийг зохицуулах
 - Дадлагын хугацааг анхаарах. Хичээлтэй давхцаж дадлага хийх нь тохиромжтой биш байдаг. Албан ёсоор дадлага хийх гэрээ байгуулдаггүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөр хоорондын уялдаа, агуулгын давхардлыг арилгахад анхаарч ажиллах хэрэгтэй байна.
- Чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж гаргах гол суурь нь дадлага байдаг. Тиймээс мэргэжлийн урлагийн байгууллагуудтай албан ёсны гэрээ хийж дадлагыг чанартай хийхэд анхаарч ажиллах
- Хэдийгээр тэргүүлэх чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр боловч багшийн ажлын байранд шаардлагатай сурган, заах арга, сэтгэл судлалын хичээлийг сонголтоор оруулах. Учир нь төгсөгчдөд ажлын байрны олдоц, хөрвөх боломжийг олгох үүднээс эдгээр хичээлийг оруулах шаардлагатай харагдаж байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 01 тоот тогтоолын хавсралт СУИС-ийн дүрмийн 6.1-6.11 дүгээр заалт, СУИС-ийн захирлын 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А/149 дүгээр тушаалын 2-р хавсралтаар батлагдсан тэнхимд тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журам, СУИС-ийн захирлын 2022.02.24 өдрийн А/56 тоот тушаалаар шинэчлэн баталсан “СУИС-ийн тэнхимд тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журам”, 2018 оны 6 сарын 25 өдрийн А/230 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар “СУИС-ийн багшийг аттестатчилах журам”, “Хөдөлмөрийн дотоод журмын 8, 10, 11. 12 дугаар зүйл, СУИС-ийн захирлын 2018 оны 5 дугаар сарын 1 өдрийн А/162 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар “СУИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм”-ийг Хөгжмийн урлаг хөтөлбөр хүний нөөцийн бодлого, зохицуулалтын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.
- СУИС нь сургалт, эрдэм шинжилгээ, уран бүтээл, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хөгжүүлэх зорилго бүхий 2018-2024 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. Стратегийн зорилт 1.3-т багшийн залгамж холбоог бэхжүүлж, шилдэг залуу багшийг бэлтгэх, сургалт судалгааны орчинд мэргэжлийн хүрээний гадаад дотоод харилцааг бэхжүүлэх зорилт тавин ажиллаж байна.
- Багш сонгон шалгаруулах тухай мэдээллийг сургуулийн цахим хуудас, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нээлттэй явуулж байна. Шалгаруулалтыг СУИС-ийн тэнхимд тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журмын 3, 6, 8, 10-р бүлэгт үндэслэн явуулдаг.
- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын бүрэлдэхүүнд одоогийн байдлаар докторын зэрэгтэй 3 багш, докторантурт суралцаж, судалгаа хийж байгаа 6 багш ажиллаж байна.
- Хөгжмийн урлаг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарыг Соёл Урлагийн Их Сургуулийн тэнхимд тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журмыг баримтлан тухайн хөтөлбөр, мэргэжлийн чиглэлээр хийж буй сургалт эрдэм шинжилгээ, уран бүтээлийн ажлын чанар, үр дүнг харгалзан а) тэргүүлэх профессор, б) профессор, в) дэд профессор, г) ахлах багш, д) багш, е) дадлагажигч багшийн албан тушаалын зэрэглэлд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулдаг.
- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь албан тушаалын зэрэглэлд тавигдах ерөнхий болоод тусгай шаардлагуудыг ханган ажилладаг.
- СУИС-ийн захирлын 2015 оны 6 дугаар сарын 05 өдрийн А/147 дугаар тушаалаар батлагдсан “СУИС-ийн профессор багш, ажилтныг шагнаж урамшуулах журам”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.
- 2021-2022 оны хичээлийн жилд буюу хаврын улиралд бүх багш нарын цалинг СУИС-ийн захирлын 2022.01.03 өдрийн А/01 тушаалаар 15 хувь, 2022-2023 оны хичээлийн жилийн намрын улиралд буюу СУИС-ийн захирлын 2022.08.29 өдрийн А/237 тоот тушаалаар үндсэн багш нарын цалинг 15 хувиар нэмсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дээд боловсролтой, мэргэжлийн өндөр ур чадвартай, мэргэжлийн урлагийн байгууллагад ажилладаг уран бүтээлчийг нөөцийн хүрэлцээ, хангамж хүртээмжээс шалтгаалан гэрээт багшаар авч ажиллуулж байна. Тухайлбал, МУАЖ, МУГЖ, МУУГЗ, МУСГЗ цолтой

Анхаарах асуудал:

- Багшлах боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хөгжүүлэх ажлыг тасралтгүй явуулахад анхаарах,
- Шинэ залуу багш профессор, судлаачдаар хүний нөөцийг чанаржуулж, бэхжүүлэх
- Багш нарын эрдмийн зэрэг цолыг ахиулахад анхаарч дэмжлэг үзүүлэн доктор зэрэгтэй багшийн эзлэх хувийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Хүний нөөцийн төлөвлөлтийг хийхдээ ажил мэргэжил, хэрэгцээний хүрээгээр нарийвчилсан судалгаа хийх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- 2018 оны 10 дугаар сарын 23-ны Эрдмийн зөвлөлийн тогтоолоор сайшаасан “Багшийн хөгжлийг дэмжих” хөтөлбөр (2018-2024) –ийг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглаж байна.
- Багш нарын мэргэжил дээшлүүлэхэд шаардагдах мэдээлэл, арга зүйгээр хангаж, нэгдсэн сургалт-семинарыг жил болгон зохион явуулдаг ба гадаад хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн зохион байгуулсан бөгөөд багш нар мөн идэвх чармайлт гарган ажилласан.
- СУИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын газраас “Багшийн хөгжил” хөтөлбөрийн талаар судалгаа авч, тус хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, сайжруулалт хийн ажилладаг.
- СУИС-ийн багшийн сургалтын үндсэн бичиг баримтын нэг болох Багшийн ажлын дэвтэр (77 дугаар хуудас) “Багшийн өөрийн хөгжлийн хөтөлбөр” гэсэн хэсэгтэй бөгөөд сургалт “А” II. эрдэм шинжилгээ, судалгаа “В” III. уран бүтээл, олон нийтийн ажил “С” бүтэцтэй байдаг.
- Үндсэн багш нарыг дотоодын магистрантур, докторантурт суралцах нөхцөл боллоцоогоор ханган, ажилласан жил, ажлын бүтээмжийг харгалзан сургалтын төлбөрийн 20-40 хувийг хөдөлмөрийн гэрээний дагуу зээл хэлбэрээр олгож хөнгөлөлт үзүүлдэг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн багаас 2021-2022 оны хичээлийн жилд “Багшийн хөгжлийн дэвтэр” хэвлэн гаргасан нь “Багшийн хөгжлийн хөтөлбөр”, СУИС-ийн багшийн жишиг загвар, багшийн чадамжийн хүрээ, ерөнхий шалгуурын дагуу өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө гаргах, сургалт, эрдэм судлалын ажлаа төлөвлөхөд нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байна.
- Монголын хүний нөөцийн хөгжлийн институттэй хамтран хувь хүний зан төлөвийн ТАИPI судалгааг СУИС-ийн 248 багш, ажилтны дунд явуулан үнэлгээ хийсэн. Үр дүнд нь СУИС-ийн багшийн чадамжийн хүрээг тодорхойлон гаргасан.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд багш бүрээр мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө гаргуулж, улмаар тэнхимийн нэгдсэн төлөвлөгөөг хийж мөрдөж ажиллах
- Нэг оюутанд 2-3 багш хамтран хичээл заах, ганцаарчилсан, бага бүлгээр хичээллэх зэргээр өндөр өртөгтэй сургалт явуулдаг, үндэсний соёл урлаг судлал, шүүмж, судалгааны арга зүй төлөвшөөгүй, профессор багш нарын цалин хөлс дээд боловсролын салбарын дундаж түвшнээс доогуур байгаа нь сургалт, эрдэм судлалын ажилд тэргүүлэх судлаач, мэргэжилтнүүдийг татан оролцуулах, чадварлаг мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллахад хүндрэл учруулж байгаа байна.
- Мөн багш нарын гадаад хэлний мэдлэг тааруу байгаагаас орчин үеийн хэрэгцээт мэдээлэл авч чадахгүй, англи хэлээр лекц унших багш нарын тоо хангалтгүй, багш нар техник технологийн дэвшлийг сургалт, судалгаанд ашиглах, хичээл суралцагчдын судалгааны ажил удирдах мэдлэг, чадвар, эрмэлзэл хангалтгүй байна хэмээн тодорхойлжээ.

Зөвлөмж:

- Нарийн мэргэжлийн боловсон хүчнийг ажилд авах тохиолдолд сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг уян хатан байдлаар боловсруулж хэрэгжүүлэх
- Багш нарын аттестатчилалын шалгуурт багшийг хөгжлийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөгжмийн онолын тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажлын үндсэн чиглэл нь:
 1. Хөгжмийн урлагийн онол арга зүйн тулгамдсан асуудлуудыг тодруулан боловсруулах
 2. Хөгжмийн урлагийн чиглэлээр өгүүлэл, шүүмж туурвих
 3. Хөгжмийн урлаг хөтөлбөрөөр суралцагсдад зориулсан сурах бичиг, гарын авлагыг хэвлүүлэх
 4. Арга зүйн чиглэлийн судалгааны ажил хийж гүйцэтгэх
 5. Семинар, сургалтад хамрагдан туршлага судлах
 6. Эрдэмтэн багш, судлаачдын арга зүйг судлах, нээлттэй хичээл зохион байгуулах
 7. Эрдэм шинжилгээний хуралд оролцох /дотоод, гадаадын/, илтгэл хэлэлцүүлэх
 - 8 Залуу багш нарыг дадлагажуулан, эрдэм шинжилгээ судалгааны ажилд татан оролцуулах.
- Судалгааны ажлынхаа үр дүнд тулгуурлан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулан /сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, CD, DVD зэрэг/ сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- “Соёл урлагийн толь-сувдан эрх” төслийн хүрээнд 2018 онд “Хөгжим” тайлбар толийг хэвлэн олны хүртээл болголоо.
- СУИС, ХУС-ийн инновацын бүтээл болох “Дөрвөн цагийн эгшиглэн буюу 12 сарын аялгуу” төслийн номын нээлт, тоглолт 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдөр СУИС-ийн “Оюутан” театрт болж, 13 хөгжмийн зохиолчийн ардын дууны хэв шинжит бүтээлүүд тоглогдсон.
- СУИС-ийн дотоодын санхүүжилттэй төслийн шалгаруулалтад ХУС-ийн хөгжмийн онолын тэнхим, төслийн санаачлагч, багш, хөгжмийн зохиолч Г.Төвшинтэр цуврал төслийнхөө гурав дахь удаагийн төслөөрөө “Хөгжимдүүрт зориулсан

инновацийн бүтээлүүд” бүтээн туурвих ажлын хүрээнд үндэсний найман хөгжимдүүр лимбэ, эвэр бүрээ, ёочин, шударга, ятга, дунд хуучир, морин хуур, их хуур, мөн төгөлдөр хуурын хоршил, хөөмийн найрал хөгжимтэй бүтээлүүдийг орчин цагийн мэргэжлийн хөгжмийн зохиолчдоор сугалуулж зохиолгон түүнийгээ эмхэтгэн хэвлүүлж сургалтын эргэлтэд орууллаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжмийн урлаг хөтөлбөрийн багш нар Хөгжмийн урлагийн сургуулийн бүх тэнхимүүдэд үйлчилгээ үзүүлдэг учраас дуулах урлаг, язгуур урлаг, хөгжимдөх урлаг, багш, урлагийн боловсрол хөтөлбөрийн оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг удирдан чиглүүлж ажилладаг.
- СУИС-ийн эрдэмтэн судлаачид эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийг улсын захиалгат суурь болон хавсарга судалгааны төсөл, олон улсын хамтарсан төсөл, өөрийн дотоод санхүүжилт, шинжлэх ухаан, технологийн сан, БСШУСЯ-ны санхүүжилт авч бүрдүүлдэг.

Анхаарах асуудал:

- ОУ-ын индексстэй сэтгүүлд багш нарын өгүүлэл, илтгэл хэвлүүлэхэд анхаарч, эрдэм судлалын ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна.
- Гадаадын ижил төстэй их дээд сургуульд туршлага судлах, ЭШХ-д оролцох боломжийг эрэлхийлж багш нарыг хамруулах. Учир нь нилээд хэдэн улстай харилцдаг гэсэн хэдий ч бодит байдалд 2-3 орноор хязгаарлагдаж байгаа байдалтай байна.
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийг тогтвортой нэмэгдүүлж, багш нарыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд илүү идэвхтэй оролцуулах шаардлага байна.

Зөвлөмж:

- Багш нарын захиалгат төсөл, гэрээт ажлын үр дүнг үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд бүтээл нийтлүүлэх, судалгааны ажил, эшлэгдсэн байдлыг тоо, чанарт анхаарч ажиллахыг зөвлөмжилж байна.
- Багш нарын судалгаа шинжилгээний ажлын туршлага, бүтээлийн жагсаалтыг өөрийн үнэлгээний тайланд тусгаж оруулах хэрэгтэй байна.
- Багшийн хөгжлийн асуудал, тэдгээрийн тоо, чанарт анхаарч эрдэмжүүлэх буюу эрдмийн зэрэг цолыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөмжилж байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- 2012 оноос 3 жил тутам, 2018 оноос 2 жил тутамд багш нарын аттестатчиллыг зохион байгуулж, үр дүнгээр нь албан тушаалын зэрэглэл, цалингийн сүлжээний шатлалыг ахиулах жишиг тогтоод байна. 2018 оноос багшийн ажлын үнэлгээг боловсронгуй болгож 360 градусаар үнэлэхдээ оюутны, хамт олны, удирдлагын зүгээс тус бүр 10 оноо буюу 30 оноо, өөрийн үнэлгээг 70 оноо болгож өөрчилсөн нь илүү ач холбогдолтой болсон.

- Хөгжмийн урлаг хөтөлбөрийн багш нар 2 жил тутам өөрийн үнэлгээний тайлан бичиж, түүнд тулгуурлан багшийн үйл ажиллагааг хянаж үнэлэх, урамшуулах, засан сайжруулах ажил тогтмол хийгдэж байна.
- Багш нарын өөрийн үнэлгээний тайланг төв сургуулиас томилогдсон комисс үнэлэн, дүн шинжилгээ хийдэг ба багш нарын өөрийн үнэлгээний дүнд тулгуурлан хангалттай ахиц дэвшилтэй ажилласан багш нарыг зэрэглэл ахиулан цалинг шинэчлэн тогтоодог.
- Багш нарын өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан цаашид багшийг хөгжүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт семинарыг бүрэлдэхүүн сургууль болон тэнхимээс зохион байгуулан ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдаас улирал бүрийн төгсгөлд багш нарын талаар судалгааг тогтмол авч багш нартаа мэдээлэл хүргүүлдэг. Судалгааны үнэлгээнд тулгуурлан багш нар өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, сургалтын үйл ажиллагааг сайжруулдаг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн уулзалтын үеэр хэд хэдэн асуудлыг анхаарах шаардлагатайг хэлж байсан. Тухайлбал,
 - Монгол хөгжим, монгол уран бүтээл дээр түлхүү ажиллуулах
 - Хөтөлбөр хоорондын уялдаа холбоог хангахад анхаарах, давхардлыг арилгах
- Ажил олгогчдын уулзалтаас дараах саналуудыг төгсөгчидтэй холбон хэлж байсан. Тухайлбал,
 - МУ-д нэн дутагдалтай мэргэжлийн анги нээх асуудал байж болох уу?
 - Элсэлтийн бодлого байхгүй байна. Ажлын байрны судалгаа авч дутагдалтай мэргэжилтэнг бэлтгэх зэргээр бодлогоор сургалтыг явуулах
 - сургууль хоорондын хамтын ажиллагааг сайжруулах. 4 жил сурах, 12 жил сурах ялгаатай. Тиймээс СУИС ямар түвшинд боловсон хүчин бэлтгэх, МУК- ямар түвшинд мэргэжилтэн бэлтгэх вэ гэдгийг зохицуулах
 - Дадлагын хугацааг анхаарах. Хичээлтэй давхцаж дадлага хийх нь тохиромжтой биш байдаг. Албан ёсоор дадлага хийх гэрээ байгуулдаггүй.
 - Ноот уншиж чадахгүй байхад диплом өгч байгааг болиулах. Диплом олгохдоо тодорхой шалгуур тавьж хангахгүй тохиолдолд өгөхгүй байх, дахин сургах хэрэгтэй.

Зөвлөмж:

- Энэ нэг сургуулийн тухайн нэг хичээлийн хөтөлбөр яригдаж байгаа хэдий ч манай улсын соёлын ажилтны хүний нөөц, тэдгээрийн чадавхийн асуудал хөндөгдөж байна. Тиймээс Соёлын яамтай хамтран соёл, урлагийн ажилтан бэлтгэх тал дээр бодлогын түвшинд шийдэх олон асуудлыг байгааг анхаарах хэрэгтэй болов уу.

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Дотоод чанарын менежментийг тогтолцоог бүрдүүлэх 6 үе шаттай үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн
- Сургалтын чанарын менежмент системийн үе шат, үйл явцыг схемээр харуулсан.
- Чанарын үнэлгээ, баталгаажуулалтыг PDCA загвараар шинжилсэн.
- “СУИС-ийн дотоод хяналт, шалгалтын журам”-ыг захирлын 2012.02.29-ий өдрийн А/75 тушаалаар баталсан.
- Дотоод үйл ажиллагааны чанарын удирдлагын тогтолцоо
- СУИС-ийн дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо
- Дотоод чанарын удирдлагын тогтолцооны төлөвлөлт /2017-2018, 2018-2019/
- Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа сүүлийн 5 жилээр
- Төгсөгчдын ажил эрхлэлтийн байдал /2016 оноос хойш/
- СУИС-ийн Сургалтын хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалтын зураглал
- Сургалтын хөтөлбөрийг боловсруулах зураглалыг PDCA загвараар боловсруулжээ.
- Хөтөлбөрийн шинэчлэл хийх 1, 2, 3, 4-р үе шат тус бүрийг схемчлэн харуулжээ.
- Хөтөлбөрийн хорооны бүтэц схемээр
- Чанарын баталгаажуулалт нь сэтгэл ханамжийн судалгаа, явцын үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, үр нөлөөний үнэлгээ, санхүүжилтийн байдлын шинжилгээ тодорхой давтамжтайгаар хийж гүйцэтгэдэг системтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо бий болсон нь

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын судалгааны статистик боловсруулалтын чанарт анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын судалгааны статистик боловсруулалтдаа SPSS программ ашиглах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- БСШУЯ, БМИҮЗ-ын хамтарсан “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд сургалтын хөтөлбөрийн зураглал (mapping) боловсруулан мэргэжлийг багцлах шаардлагын дагуу 021501 индексстэй “Хөгжмийн урлаг” хөтөлбөрийг багцлан боловсруулсан байна.
- Хөтөлбөрийн зарилго, зарилтыг үнэлэх, сайжруулах үйл ажиллагааны зураглал
- Төгсөгчдөөс авсан санал асуулгын дүн
- Төгсөөд ажлын байранд очих хүртэлх хугацааны судалгаа
- Ажил олгогчоос авсан Судалгаа1,2,3,4-ийн хүснэгтэн мэдээлэл болон диаграммууд
- ХОТ-ийн Хөгжмийн урлаг хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд багш нараас авсан судалгаа
- ХОТ-ийн Хөгжмийн урлаг хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд оюутнуудаас авсан судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХОТ-ийн Хөгжмийн урлаг хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд багш болон оюутнуудаас судалгаа авсан

Анхаарах асуудал:

- Ажил олгогчоос авсан Судалгаа 1,2,3,4, ХОТ-ийн Хөгжмийн урлаг хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд оюутнуудаас авсан судалгаа Судалгаа5,6,7,8-ийн хүснэгтэн мэдээлэл болон диаграммууд байгаа боловч дүгнэлтүүддээ үзүүлэлт хоорондын хамаарлуудыг тооцоогүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, салбарын хөгжилд хувь нэмрээ хэрхэн оруулж буйш илрүүлэх судалгааг тодорхой давтамжтай авч, судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутнуудын улсын болон олон улсын чанартай сургалт, судалгаа, уран бүтээлийн үйл ажиллагаанд оролцсон байдлын судалгаа /2016-2022/
- Чанарын үнэлгээ баталгаажилтад хийсэн SWOT, TOWS шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Туршлага болохуйц онцлог зүйл ажиглагдсангүй

Анхаарах асуудал:

- Цаашид энэхүү хөтөлбөрийг олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлэх болон суралцагчид суралцах хугацаандаа оюутан солилцоо болон 2+2, 1+3 хөтөлбөрөөр суралцах боломжийг нээх

Зөвлөмж:

- Цаашид энэхүү хөтөлбөрийг олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлж, төгсөгчид ямар ч оронд үргэлжлүүлэн суралцах боломжийг нээж өгөх

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн Хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /Хэсэгчлэн хагасан болон хангаагүй үед/
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2 Сургалтын үйл ажиллагаа	2			
3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5 Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6 Багшийн үйл ажиллагаа	2			
7 Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт	Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Соёл Урлагийн Их Сургуулийн Хөгжмийн урлагийн сургуулийн “Хөгжмийн урлаг” 021501 индекстэй бакаларын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

№	Шалгуур	Зөвлөмж
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none">- Хөдөө орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагуудад ажиллаж буй хөгжим судлаач, хөгжмийн зохиолч, найруулагч, удирдаачдын эрэлт хэрэгцээнээс гадна УБ хотын мэргэжлийн байгууллагуудын эрэлт хэрэгцээг судлах- Энэхүү мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, эргэх холбоотой ажиллах бүхий л үйл ажиллагаандаа ажил олгогч болон сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх- “Хөгжмийн урлаг” Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх дээр шинжилгээ хийх- Тухайн хөтөлбөрийн PLO-үүдийг суралцагчид 4 жилийн хугацаанд судалдаг бүх хичээлүүдийн CLO-уудтай бүрэн матрицлах шаардлагатай.
2	Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none">- Дадлагыг чанартай, үр өгөөжтэй хийлгэхэд анхаарч ажиллах- СУИС-ийн зүгээс хөгжмийн сүүлийн үеийн лицензтэй программ худалдан авах- Шинэ уран бүтээлийн тоглолтуудыг үзэх эрхийг оюутнуудад өгч ажиллах
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none">- Компьютер хэрэглээний хичээлийн агуулгыг эрс сайжруулах, оюутнуудын сонирхлыг татах, хамгийн орчин үеийн технологийн ололтыг аль болох ойлгож эзэмшсэн багшаар хичээл заалгах, хичээлийг орчин үеийн техник технологийн тусламжтай явуулах, оюутны хөгжил төвийг дэлхийн их сургуулийн оюутны хөгжлийн туршлага судлан идэвхтэй ажиллуулах- Монгол хэл дээр ном сурах бичгийг нэмэгдүүлэхэд анхаарах- Сургалтын аудио, видео хэрэглэгдхүүн буюу баримтат өв, үзэх харах сонсох эх хэрэглэгдхүүний тоог нэмэх хэрэгтэй- Багш оюутны цахим мэдлэгийг сайжруулахад түлхэц өгөх янз бүрийн арга хэмжээг зохион байгуулж энэ талаар ур чадвартай багш нарыг урамшуулж дэмжих нь зүйтэй.

		<ul style="list-style-type: none"> - Хөгжим судлаач багш нарт нарийн мэргэжлийн ном товхимол бичих, орчуулга хийхэд цагийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Хөгжмийн урлагийн хөтөлбөрийг тодорхой хугацаанд шинэчлэн боловсруулж байх нь сургалтыг сайжруулах орчин үеийн технологийн хурд, ур чадвар сэтгэлгээний түвшинд хүргэх ач холбогдолтой - Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын журмыг шинэчлэн батлах, багш нарын оролцоог дүгнэн “Б” цагт оруулан тооцох боломжтой - Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн хэрээр хөтөлбөрийн төлөвлөлт биелэлтийн үйл ажиллагаанд зарцуулж сургалтын чанарт нөлөөлөх - Хөгжмийн урлаг хөтөлбөрт хамрагдсан үе үеийн бахархалт төгсөгчидтэй уулзалт хийх, нээлттэй ярилцлага өрнүүлэх, подкаст хийх г.м. олон чиглэлээр үр дүнтэй ажиллаж оюутнуудын одоогийн суралцах арга барилд өөрчлөлт хийх хэрэгтэй - Хөгжмийн ухааны тэнхимийн багш нарын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг сурталчлах, түгээх PR хийх хэлбэрийг сайжруулах
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Олон улсын болон дотоодын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөтгөж, багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт болон хамтарсан хөтөлбөрт хамрагдах оюутны тоог нэмэгдүүлэх - Оюутны хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрүүдийн талаар цаг тухай бүрд нь мэдээллийг хүргэж, зөвлөн туслах - Өөрийн үнэлгээний тайланд оюутны урамшууллын тогтолцооны талаар харьцангуй бага тусгагдсан байгааг анхаарч нэмж оруулах - Хөтөлбөр хоорондын уялдаа, агуулгын давхардлыг арилгахад анхаарч ажиллах - Чадварлаг боловсон хүчнийг бэлтгэж гаргах гол суурь нь дадлага байдаг. Тиймээс мэргэжлийн урлагийн байгууллагуудтай албан ёсны гэрээ хийж дадлагыг чанартай хийхэд анхаарч ажиллах - Хэдийгээр тэргүүлэх чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр боловч багшийн ажлын байранд шаардлагатай сурган, заах арга, сэтгэл судлалын хичээлийг сонголтоор оруулах. Учир нь төгсөгчдөд ажлын байрны олдоц, хөрвөх боломжийг олгох үүднээс эдгээр хичээлийг оруулах шаардлагатай харагдаж байна.

6	Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Хүний нөөцийн төлөвлөлтийг хийхдээ ажил мэргэжил, хэрэгцээний хүрээгээр нарийвчилсан судалгаа хийх. - Нарийн мэргэжлийн боловсон хүчнийг ажилд авах тохиолдолд сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг уян хатан байдлаар боловсруулж хэрэгжүүлэх - Багш нарын аттестатчиллын шалгуурт багшийн хөгжлийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх - Багш нарын захиалгат төсөл, гэрээт ажлын үр дүнг үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд бүтээл нийтлүүлэх, судалгааны ажил, эшлэгдсэн байдлын тоо, чанарт анхаарч ажиллах - Багш нарын судалгаа шинжилгээний ажлын туршлага, бүтээлийн жагсаалтыг өөрийн үнэлгээний тайланд тусгаж оруулах - Багшийн хөгжлийн асуудал, тэдгээрийн тоо, чанарт анхаарч эрдэмжүүлэх буюу эрдмийн зэрэг цолыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын судалгааны статистик боловсруулалтдаа SPSS программ ашиглах - Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, салбарын хөгжилд хувь нэмрээ хэрхэн оруулж буйг илрүүлэх судалгааг тодорхой давтамжтай авч, судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах - Цаашид энэхүү хөтөлбөрийг олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлж, төгсөгчид ямар ч оронд үргэлжлүүлэн суралцах боломжийг нээж өгөх

V. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Оюутны нэрс

Оюутнууд

№	Овог нэр	Курс	Сонгосон байдал
1	Г.Мөнх-Оргил	I к	Өдөр
2	Г.Тэргэл		Өдөр
3	Х.Дөлгөөн		Өдөр
4	Г.Долгион		Өдөр
5	Б.Азхүү		Өдөр
6	М.Буяндорж		Өдөр Дотуур байранд
7	Ц.Хүслэн	II к	Өдөр
8	Б.Батзолбоо		Өдөр Дотуур байранд
9	Н.Мөнх - Болор		Өдөр Дотуур байранд
10	Х.Цэцэн		Өдөр
11	Ч.Ариунгэрэл		Өдөр
12	Г.Тэмүүлэн		Өдөр
13	Э.Нармандах	III к	Өдөр Дотуур байранд
14	С.Энхдалай		Өдөр
15	Н.Оргил	IV к	Өдөр
16	Н.Эрдэнэсайхан		Өдөр
17	М.Жанлав		Өдөр
18	Б.Мэнд - амар		Өдөр
19	Л.Ангараг		Өдөр

II. Багш, ажилтны нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Ажилласан жил	Эрдмийн зэрэг цол	Утас	Заадаг хичээл
1	Хайдав Ариунаа	Тэнхмийн эрхлэгч	27 жил	Магистр	99191399	Хөгжмийн түүх, Хөгжмийн театрын түүх, Хөгжмийн онол, Зохирлын ухаан, Хөгжим судлал, Соноршуулга, Хөгжмийн шүүмж
Үндсэн багш нар						
2	Жүгдэр Төгсжаргал	Ахлах багш	26 жил	Магистр	99890570	Хөгжмийн онол, Зохирлын ухаан, Соноршуулга
3	Түмэннасан Жандаг	Багш	26 жил	Магистр	99040213	Хөгжмийн онол, Зохирлын ухаан, Соноршуулга, Хөгжмийн хэлбэр, Олон хоолойн ухаан
4	Шатар Өлзийбаяр	Багш	20 жил	Магистр	99089197	Хөгжмийн зохиомж, Авад зохиомж, Найрал хөгжмийн найралжуулга, Орчин үеийн гармони,
5	Хүрэлбаатар Баасансүрэн	Багш	18 жил	Магистр	99894818	Хөгжмийн онол, Зохирлын ухаан, Соноршуулга
6	Гантөмөр Отгонбаяр	Багш	13 жил	Магистр	88028797	Хөгжмийн онол, Зохирлын ухаан, Соноршуулга
Гэрээт багш нар						
7	Дашням Ариунаа	Ахлах багш	31 жил /23 жил	Доктор (Ph.D)	99017093	Хөгжмийн онол, Зохирлын ухаан, Хөгжмийн түүх, Хөгжим судлал, Хөгжмийн шүүмж, Угсаатны хөгжим судлал
8	Довчин Цэцэрлэг	Ахлах багш	40 жил /33 жил	Магистр	99992330	Соноршуулга
9	Жамъян Чулуунцэцэг	Ахлах багш	54 жил /33 жил/	Доктор (Ph.D)	99085950	Удирдаачийн үндэс, Удирдах урлагийн түүх, Хөгжмийн онол,

						Соноршуулга, Угсаатны хөгжим судлал
10	Мөнхтөмөр Мөнгөнсүх	Багш	18 жил /2 жил/	Магистр	99091667	Хөгжмийн онол, Соноршуулга,
11	Гүргэлсүрэн Төвшинтөр	Багш	35 жил /12 жил/	Магистр	88834587	Хөгжмийн зохиомж, MIDI хөгжмийн зохиомж, Удирдвар уншвар
12	Цэндээхүү Эрдэнэбат	Багш	8 жил	Бакалавр	91918276	Хөгжмийн зохиомж, Найрал хөгжмийн найралжуулга /Үндэсний/, Орчин үеийн хөгжмийн зохиомжийн техник, Хөгжмийн зэмсэг судлал /Симфони, үндэсний/
Цагийн багш нар						
13	Нямаа Туулайхүү	Багш	42 жил /14 жил/	Магистр	99168966	Удирдах ур чадвар, Удирдаачтай ажиллах
14	Э.Зулцэцэг	Дэд профессор	20 жил	Доктор (Ph.D)	99170843	Хөгжмийн онол, Соноршуулга, Хөгжмийн зохиолын шинжлэл, Хөгжим судлал, Хөгжмийн шүүмж

III. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэр	Төгссөн он	Мэргэжил	Ажиллаж буй байгууллага, Албан тушаал	Утасны дугаар
1	Т.Сэр-Од	1998	Хөгжим судлаач, хөгжмийн зохиолч	DoResound продакшны захирал, Хөгжмийн зохиолч, судлаач	85488548
2	Б.Мөнхжаргал	2000	Дуу хөгжмийн багш-найрал дууны удирдаач	СУИС багш	91225995
3	А.Ариунзаяа	2002	Дуу хөгжмийн заах арга-найрал дуу удирдах урлаг	ЦДБЧ Ерөнхий хормейстер	96001681
4	С.Бүжигмаа	2006	Хөгжим судлал	Франц улсад ажилладаг	

5	Х.Мөнхтуяа	2009	Хөгжим судлал	Шанхай, СУИС багш	99993154
6	П.Ганбат	2010	Хөгжмийн зохиолч	БГД Хүүхэд хөгжлийн газрын дарга	96966670
7	Д.Батсүх	2010	МУБИС багш	Багш, Хөгжмийн зохиолч	99837240
8	Ш.Ариунчимэг	2013	Хөгжмийн багш-Найрал дуу удирдах урлаг	Шинэ эрин лаборатори сургууль, багш	99205755
9	Ө.Энхтуяа	2017	Улаанбаатар Элит ОУСургууль	Хөгжмийн багш	88717076
10	П.Насан-Очир	2018	Найрал хөгжмийн удирдаач	Ховд аймаг Хөгжимт драмын театр, Дарга	99948767
11	Ц.Тэлмүүн-Очир	2018	Хөгжмийн найруулагч, удирдаач	Дуурь бүжгийн эрдмийн театр, Удирдаач	89949788
12	Э.Шүтээн		Хөгжмийн зохиомж	ХБНГерман улсад суралцаж, ажиллаж байгаа	
13	Б.Өнөржаргал	2021	Хөгжмийн зохиолч	Сити Их сургууль, ХУТ-ийн эрхлэгч	85769112
14	Ц.Алмаз	2022	Хөгжмийн зохиомж /MIDI/	Солонгос улсад суралцаж байгаа	
15	Г.Одонтуяа	2022	Найрал дуу удирдах урлаг	Human олон улсын ЕБСургууль, Хөгжмийн багш	86222528

IV. Ажил олгогчдын нэрс

№	Байгууллага	Нэр	Албан тушаал	Утас
1	УДБЭТ	Н.Дашбямба	Ерөнхий хормейстр	99184035
2	Монгол Улсын филармони	Д.Хосбаяр	Уран бүтээлийн албаны дарга	88006089
3	ҮУИТеатр	Н.Буянбаатар	Ерөнхий удирдаач	89111129
4	ЦДБЭЧ	Баттөр	Уран сайхны удирдагч	89061615
5	ХЦДБЧ	Б.Болдбаатар	Уран сайхны удирдагч	
6	МУКонсерватори	Х.Алтангэрэл	Хөгжим, дуулаачийн сургууль захирал	99021225
7	Завханы театр	Солонго	Дарга	99083843
8	Архангайн театр	Нямсүрэн	Дарга	
9	DoreSound /хувийн /	Т.Сэр-Од	Захирал	90909065

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
 [Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
 [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/